

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.21 № 11

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 21 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Р.ЦЭВЭЛСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагааны зарцуулах баталсан төсөв, төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, төсвийг 8.0 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 92.0 хувьтай тайлагнаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 89,212.7 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

Аудитын гол асуудал

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 27.8 хувиар өсөж, төсвийн хуваарийг 9 удаа өөрчлөн, 2023 оны 12 дугаар

сарын 25-нд сүүлийн хуваарийг баталж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 90.7 хувьтай үнэлж, өмнөх оноос 1.5 хувиар өссөн байна

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 280 хүүхдээр тооцсон боловч 359 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	85,436,276.54	153,913,951.36
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,444,648,639.33	2,605,338,473.71
	Нийт хөрөнгийн дүн		
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,530,084,915.87	2,759,252,425.07
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,530,084,915.87	2,759,252,425.07
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,425,755,057.82	1,334,454,649.20
	Үйл ажиллагааны зардлын дүн	896,971,813.29	1,105,287,140.00
	Үйл ажиллагааны үр дүн	2,528,783,244.53	229,167,509.20
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,528,783,244.53	229,167,509.20
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,577,389,626.84	1,577,389,626.84
	Тайлант оны үр дүн	0	229,167,509.20
	Эцсийн үлдэгдэл	1,577,389,626.84	2,759,252,425.07
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	844,791,675.00	1,124,275,200.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	827,632,712.84	1,052,732,191.90
	Үйл ажиллагааны ЦМГ	17,158,962.16	71,543,008.10
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	17,158,962.16	71,543,008.10
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	17,158,962.16	71,543,008.10
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	17,669,763.22
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,669,763.22	89,212,771.32
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,046,668,436.00	1,049,199,821.97
	Урсгал зардал	1,046,668,436.00	1,049,199,821.97
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,110,212,121.97
	Улсын төсвөөс санхүүжих		1,049,199,821.97
	Орон нутгийн төсвөөс		61,012,300

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,889.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитаар илрүүлсэн зөрчлийн асуудлын бүртгэл хөтлөн баталгаажуулж, 289.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт:

Сахилгын шийтгэлтэй ажилчдад 289.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага:

Нийт ажилтан албан хаагчдад "Зорилгоо тодорхойлж түүндээ хүрэх багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх арга зүй" сэдэвт сургалт зохион байгуулж 1,600.0 мянган төгрөг шилжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалин хөлс бодож олгохдоо цагийн бүртгэл, цагийн нэгтгэл хоёр хоорондоо зөрүүтэй баримтаар бодож олгосон зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Өгсөн зөвлөмж: Жижүүрийн цагийн бүртгэлийг үндэслэн цагийн нэгтгэлийг гаргаж байх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулах мэдээ мэдээллээ хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 6.1- д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 8.4-д "Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг ил тод, үнэн зөв, хугацаанд нь байршуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

												/сая.төгрөг/	
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Улаанбаатар хотод албан томилолтоор ажиллах зардлыг 120,000 төгрөгийг илүү олгосон байна.	1	0.1					1	0.1					
Дүн	1	0.1					1	0.1					

/сая.төгрөг/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй ажилчдад 289.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	0.2	1	0.2								
Цалин хөлс бодож олгохдоо цагийн бүртгэл, цагийн нэгтгэл хоёр хоорондоо зөрүүтэй баримтаар бодож олгосон байна.	1	0					1	0				
Дүн	2	0.2	1	0.2			1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах мэдээ мэдээллээ хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Маргад дээд сургуулийн багшаар нийт ажилтан албан хаагчдад "Зорилгоо тодорхойлж түүндээ хүрэх багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх арга зүй" сэдэвт сургалт зохион байгуулж 1,600,000 төгрөг шилжүүлсэн байна	1	1.6			1	1.6		
Дүн	1	1.6			1	1.6		
Нийт дүн	2	1.6			1	1.6		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	--------------------------	-------------------------

	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			